



**МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.11.10 № 01/3594


танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН М.БАДАМСҮРЭН
ТАНАА**

Танаас ирүүлсэн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 46 дугаар албан бичигтэй танилцаж, Малчны тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой тус яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ...5... хуудастай.

Хүндэтгэсэн,



Т.АУБАКИР

**Малчны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор малчны тэтгэврийн
даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой авч
хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл**

2025.11.10

1. Малчны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөхөөр заасан тул өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан журмыг Засгийн газраар батлуулсан эсэх асуулгын хүрээнд;

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх” гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна” гэж, мөн хуулийн 16.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө” гэж тус тус заасан.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам”-ын төслийг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1416 дугаар албан бичгээр Засгийн газрын “Журам батлах тухай” тогтоолын төсөлд яамдаас санал авахаар хүргүүлсэн.

Тус тогтоолын төсөлд Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/10303 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т заасан “... Засгийн газрын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэн байх” гэсэн зарчмын дагуу тогтоолын төсөлтэй холбоотойгоор нийгмийн даатгалын санд ирэх жилүүдэд үүсэх алдагдлын талаар нарийвчилсан тооцоо, судалгааг ирүүлсний үндсэн дээр уг асуудлыг дахин авч үзэх талаар санал ирүүлсэн. Үүний дагуу холбогдох тооцоо судалгааг хийж, журмын төсөлд “10-аас дээш жил шимтгэл төлсөн малчин даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 5 хүртэл жилээр тооцон төлүүлэх”-ээр тусган 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/531 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Сангийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/1936 дугаар албан бичгээр нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчлэх, тогтолцооны шинэчлэл

хийх асуудалтай хамтад нь дахин авч үзэх нь зүйтэй ба тогтоолын төслийг дэмжих боломжгүй талаар санал ирүүлсэн болно.

Мөн тус яамнаас 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3039 дугаар албан бичгээр “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг удаа нөхөн төлүүлэх журам” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс дахин санал авахаар хүргүүлсэн.

Сангийн яамнаас 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/9388 дугаар албан бичгээр тогтоолын төслийг баталснаар шаардагдах зардал Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусаагүй байх тул тогтоолын төслийг дэмжих боломжгүй талаар, мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 1/1572 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх”-аар зааж төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг хэрэгжүүлдэг тул малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр тус асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй талаар тус тус санал ирүүлээд байна.

“Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг удаа нөхөн төлүүлэх журам”-ын төсөлд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 1995-2025 онд малчнаар ажиллаж байсан болон ажиллаж байгаа, 5 ба түүнээс дээш жил шимтгэл төлсөн малчин даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 5 хүртэл жилээр нэг удаа нөхөн төлүүлэхээр тусгасан болно.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 5 хүртэл жилээр тооцон нөхөн төлүүлэхэд 38.2 мянган малчин хамрагдаж, тэтгэврийн даатгалын санд 194.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрөх тооцоолол байна.

Улмаар эхний жил буюу 2026 онд 4.6 мянган малчны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх бөгөөд тэдний тэтгэвэрт 29.9 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоололтой байна. Энэхүү тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг жил бүр олгох юм. Мөн цаашид тэтгэвэр авагчийн өсөлттэй уялдан тэтгэврийн даатгалын сангийн зардал эрс нэмэгдэх тооцоололтой байна.

Малчны нийгмийн хамгааллын талаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд дараах онцлог зохицуулалтыг тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

Малчны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцан төлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.23 дахь хэсэгт “Малчин, туслах малчин сайн дураар даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна” гэж заасан. Энэ хүрээнд 2024 онд 51.5 мянган малчин нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж, тэдний шимтгэлийн зардалд улсын төсвөөс 24.4 тэрбум төгрөгийг хариуцан төлсөн.

Мөн 2025 онд улсын төсвөөс 26.4 тэрбум төгрөг төсөвлөснөөс 2025 оны эхний 9 сарын байдлаар 51.7 мянган малчин нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж, тэдний шимтгэлийн зардалд улсын төсвөөс 19.5 тэрбум төгрөгийг хариуцан төлөөд байна.

Малчид өндөр насны тэтгэвэрт гарах ердийн наснаас 5 жилийн өмнө тэтгэвэрт гарч байна.

Малчин эмэгтэй 50 нас, эрэгтэй 55 насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

-нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй;

-нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Энэ хүрээнд 2024 онд тэтгэврийн даатгалын сангаас 32.3 мянган малчны өндөр насны тэтгэвэрт 237.0 тэрбум төгрөг, 2025 оны эхний 9 сарын байдлаар 33.7 мянган малчны өндөр насны тэтгэвэрт 211.0 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

2.Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн болон бусад мэдээллийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг хүссэн асуулгын хүрээнд;

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх 2 удаагийн хуулийг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлаас 2012 онд Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд тус хуулийн үйлчлэлд 607.8 мянган иргэн хамрагдаж, 37.9 тэрбум төгрөгийг нөхөн төлсөн.

Одоогийн байдлаар энэхүү хуулийн үйлчлэлд хамрагдсан 324.1 мянган хүн тэтгэвэр тогтоолгоод байгаа бөгөөд тэдний тэтгэвэрт 1,898.7 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Цаашид хуулийн үйлчлэлд хамрагдсан иргэд тэтгэвэр тогтоолгосноор энэхүү зардал жил бүр нэмэгдэж байна.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хуулийн хэрэгжилтийн дүн

Үзүүлэлт		
1.	Шимтгэлээ нөхөн төлсөн даатгуулагчдын тоо	607.8 мян.хүн
2.	Төвлөрүүлсэн шимтгэл	37.9 тэрбум төг
3.	Нийт тэтгэвэр тогтоолгосон хүний тоо	324.1 мян.хүн
4.	Нийт тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө	1,898.7 тэрбум төг
5.	Алдагдал /2024 оны байдлаар/	1,860.7 тэрбум төг /4-2/

2. Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан улмаар 2020, 2021 онд хэрэгжүүлсэн. Хуулийн үйлчлэлд 34.4 мянган иргэн хамрагдаж, 76.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн нөхөн төлсөн хэдий ч одоогийн байдлаар хуулийн үйлчлэлд хамрагдсан иргэдээс 20.6 мянган хүн тэтгэврээ тогтоолгож, тэдний тэтгэврийн зардалд 205.7 тэрбум төгрөг зарцуулаад байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн дүн

Үзүүлэлт		
1.	Шимтгэлээ нөхөн төлсөн даатгуулагчдын тоо	34.4 мян.хүн
2.	Төвлөрүүлсэн шимтгэл	76.4 тэрбум.төг
3.	Нийт тэтгэвэр тогтоолгосон малчны тоо	20.6 мян.хүн
4.	Нийт тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө	205.7 тэрбум.төг
5.	Алдагдал /2024 оны байдлаар/	129.3 тэрбум.төг /4-2/

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “энэ хуулийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хориглоно.” гэж тус тус заасан.

Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх нь зарим иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах хэдий ч шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн

хэмжээнээс хамаарсан тэтгэвэр, тэтгэмж авах агуулга бүхий нийгмийн даатгалын тогтолцоонд шударга бус байдлыг бий болгож байна.

Түүнчлэн, авч байсан цалин хөлс болон шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоосон тэтгэврийн хэмжээ хоорондын хамаарлыг сулруулж байгаа бөгөөд энэ талаар олон жил хөдөлмөрлөж, нийгмийн даатгалын шимтгэл төлж тэтгэвэр тогтоолгож байгаа тэтгэвэр авагчид гомдол санал ихээр ирүүлж байна.

---oOo---



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.10.27 № 46

Малчны тухай хуулийн
хэрэгжилтийн талаар


Малчны эрх зүйн байдлыг тодорхойлон малчдын ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар Малчны тухай хуулийг 2024 онд Улсын Их Хурлаас баталсан бөгөөд энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх”, 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна” гэж тус тус хуульчилсан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад заасныг тус тус үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна.

1. Малчны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөхөөр заасан тул өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан журмыг Засгийн газраар батлуулсан эсэх;

2. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн болон бусад мэдээллийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



М.БАДАМСҮРЭН